



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДЭЛГЭРХААН СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 03 өдөр

Дугаар А/05

Аварга

Ажил мэргэжлийн жагсаалт,
Цалин, нэмэгдэл шинэчлэн тогтоох

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1, 103 дугаар зүйлийн 103.3.1 дэх хэсэг, Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 240 дүгээр тогтоолын 5, 6, 7 дугаар хавсралт, 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолын 9, 10, 11 дүгээр хавсралт 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 491 дүгээр тогтоол "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам", 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 82 дугаар тогтоол "Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Албан хаагчдын ажил мэргэжлийн жагсаалт, цалин, нэмэгдлийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2. Шинэчлэн тогтоосон цалин хөлс, нэмэгдлийг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тооцон олгохыг нягтлан бодогч (Б.Алтантуяа)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаал гарсантай холбогдуулан Соёлын төвийн даргын 2024 оны 01 дүгээр сарын 02-ний өдрийн А/01 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Н.ДОРЖНАМЖИЛ